



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

Дээд боловсролын сургалтын байгууллагын
чанарын үнэлгээтэй холбоотой зарим
асуудлыг зохицуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Засгийн газрын 2026 оны “Боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг болон үндэсний уламжлалт үнэт өв, шашны чиглэлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарын үнэлгээний үр дүнг төрийн болон албаны нууц, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой мэдээллийн нууцлалын шаардлагыг харгалзан нийтэд ил тод мэдээлэхгүй байхаар тогтоосугай.

2.Энэхүү тушаалын 1-д заасан зохицуулалтад хамаарах дээд боловсролын сургалтын байгууллагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Сүүлийн 3 хичээлийн жилийн хугацаанд дээд боловсролын сургалтын байгууллагууд нэгдсэн тохиолдолд эрх хүлээн авагч сургуулийн саналыг үндэслэн, нэгтгэсэн сургуулийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарын үнэлгээнд шууд нэгтгэхгүйгээр тусад нь үнэлэхийг зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Дээд боловсролын бодлогын газар (Б.Түмэндэлгэр), дээд боловсролын цахим мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлэлт, баталгаажуулалтыг зохион байгуулахыг Боловсролын ерөнхий газар (Х.Тамир), эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарын тогтоох үйл ажиллагааг арга зүйн удирдлагаар хангаж зохион байгуулахыг Боловсролын үнэлгээний төв (Э.Цэрэнцоодол)-д тус тус даалгасугай.

5.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (В.Түвшинжаргал)-т даалгасугай

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

1426010567

Боловсролын сайдын 2026 оны
06 дугаар сарын 25-ны өдрийн
А/1168 дугаар тушаалын хавсралт



ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Сургалтын байгууллагын нэр	Сургалтын чиглэл <i>/үнэлгээний үр дүнг зарлахгүй байх үндэслэл/</i>
1.	Үндэсний тагнуулын их сургууль	Төрийн тусгай чиг үүрэг бүхий стратегийн онцгой салбарын мэргэжилтэн бэлтгэдэг
2.	Үндэсний батлан хамгаалахын их сургууль	Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд хамаарах стратегийн салбарын мэргэжилтэн бэлтгэдэг
3.	Дотоод хэргийн их сургууль	Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын ажилтан бэлтгэдэг
4.	Монголын Бурханы шашны их сургууль	Үндэсний уламжлалт өв, шашны чиглэлийн тусгай хөтөлбөртэй
5.	Оточ манрамба их сургууль	Үндэсний уламжлалт өв, шашны чиглэлийн тусгай хөтөлбөртэй

---o0o---